

**УБСЕГ: Тухайн үед (2016 онд) Үндэсний статистикийн хороо нь Улсын бүртгэлийн ерөнхий газартэй нэгдэж Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар нэртэй байсан болно.**

**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД, ТХЗ-ЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ТҮҮНИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ, АРГА ЗҮЙД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УБСЕГ нь Монгол улсын Ерөнхий сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2016 оны 3 дугаар сарыг 22-ны өдрийн захирамжаар байгуулагдсан “Тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлтийг үнэлэх аргачлалыг тодорхойлох” 9 дүгээр ажлыг хэсгийг ахалж, дангаараа хариуцан гаргах үүргийг хүлээж ажиллалаа.

Ажлын удирдамжийн дагуу ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүд, түүнийг тооцох аргачлал, арга зүйд хийсэн үнэлгээний тайланг бэлтгэн танилцуулж байна. Тайлан нь 1) ТХЗ-той холбоотой хийж, гүйцэтгэсэн ажлууд, 2) ТХЗ-ын үзүүлэлтийг тооцох аргачлал, арга зүйд хийсэн үнэлгээ, 3) ТХЗ-ын үзүүлэлтүүдэд хийсэн үнэлгээ, 4) Тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлтийг тооцох, гаргах чиглэлээр цаашид хийгдэх шаардлагатай ажлууд гэсэн хэсгүүдээс бүрдэж байна.

**1. ТХЗ-той холбоотой хийж, гүйцэтгэсэн ажлууд.** Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд 2015-2016 онуудад УБСЕГ-аас дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ТХЗ-ыг үндэсний хэмжээнд таниулах, сурталчлах ажлын хүрээнд ТХЗ-той холбоотой 8 удаагийн илтгэл, танилцуулгыг бэлтгэж, олон улсын болон үндэсний хэлэлцүүлэг, уулзалт, семинаруудад бэлтгэн хэлэлцүүлэх, ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг эх хэл дээрээ хөрвүүлэн орчуулж, яамд, төрийн бусад холбогдох байгууллагуудад хүргүүлэх ажлуудыг зохион байгуулж, гүйцэтгэв.
- ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, санал, зөвлөмж бэлтгэх, үнэлэх, ажлуудыг холбогдох яам, байгууллагуудтай хамтран гүйцэтгэж, НҮБ-ын статистикийн хэлтэс, бүсийн түвшний байгууллагуудад 4 хүргүүлэх ажлыг гүйцэтгэв. Энэ ажилд БОНХАЖЯ, Сангийн Яам, Эрүүл мэнд, Спортын яамдууд идэвхтэй хамтран ажилласан.
- НҮБ-ын статистикийн комиссоос байгуулсан ТХЗ-ын өндөр түвшний ажлын хэсэгт Зүүн Азийн бүсийн төлөөлөн оролцож, санал, зөвлөмж боловсруулах, хүргүүлэх, үнэлгээ хийх ажлуудыг гүйцэтгэж байна.
- ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдэд хийсэн үнэлгээний ажилд олон улсын болон үндэсний зөвлөхтэй хамтран ажиллаж, үр дүнг тархаах семинарыг Сангийн яам, НҮБ-ын ХХ-тэй хамтран зохион байгуулав.
- “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-ын боловсруулах ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, шаардлагатай мэдээллийг бэлтгэх, гаргах

чиглэлээр хамтран ажиллаж, 3 удаагийн хэлэлцүүлэгт оролцсон. Тухайлбал: Дэлхийн түвшинд тодорхойлогдсон үзүүлэлтүүдээс үндэсний түвшний тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгах үзүүлэлтүүдийн саналыг хүргүүлэх, дэлгэрэнгүй танилцуулгыг ажлыг хэсгийн гишүүдэд хийх, шаардлагатай тоо, мэдээллийг бэлтгэн хүргэх зэрэг ажлуудыг хийсэн.

- “ТХЗ-ын үзүүлэлтийг үнэлэх, аргачлалыг тодорхойлох” үүрэг бүхий ажлын хэсгийг дангаар хариуцан ажиллаж, мөн үндэсний түвшний үзүүлэлтийг тодорхойлох бусад холбогдох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хамтран оролцов.

**2. Тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлтийг тооцох аргачлал, арга зүйд хийсэн үнэлгээ.** НҮБ-ын Статистикийн комисоос батлагдсан “Бүс, дундын ажлын хэсэг”-ээс ТХЗ-ын шалгуур 241 үзүүлэлтийг 2016 оны 3 сарын 24-ны байдлаар тодорхойлж, улс орнуудад ирүүлсэн.

ТХЗ-ын шалгуур 241 үзүүлэлтийг тооцон гаргахад ашиглагдах аргачлал, арга зүйн бэлэн байдлын үнэлгээг тус ажлын хэсгээс гаргасан “ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн мета мэдээллийн сан”-д суурилан хийлээ.

Үнэлгээгээр ТХЗ-ын шалгуур 241 үзүүлэлтийн 135 нь буюу 56.0 хувь нь тооцох аргачлал, арга зүйтэй, 106 буюу 44 хувь нь тооцох аргачлал, арга зүй нь одоогоор тодорхой бус, бэлэн болоогүй байна. Үр дүнг хүснэгт 1-д, зорилго тус бүрээр харуулав.

Хүснэгт 1

**Тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлтийг тооцох аргачлал, арга зүйд хийсэн үнэлгээ\***

Зорилго	Зорилгын нэр	Үзүүлэлт, бүгд	ОУ-ын нэгдсэн аргачлал, арга зүйтэй эсэх	
			Тийм	Үгүй
1	Ядуурлыг устгах	12	6	6
2	Өлсгөлөнг зогсоох	14	10	4
3	Эрүүл мэндийг дэмжих	26	19	7
4	Чанартай боловсролыг дэмжих	11	5	6
5	Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах	14	11	3
6	Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	11	10	1
7	Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	6	4	2
8	Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох	17	15	2
9	Инноваци болон дэд бүтцийг нэмэгдүүлэх	12	6	6
10	Тэгш бус байдлыг бууруулах	11	4	7
11	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	15	6	9
12	Хариуцлагатай хэрэглээг дэмжих	13	3	10
13	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	7	1	6
14	Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах	10	0	10
15	Хуурай газрын эко системийг хамгаалах	14	9	5
16	Энх тайван, шударга ёсыг цогцлоох	23	15	8
17	Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	25	11	14

	<b>Дүн</b>	<b>241</b>	<b>135</b>	<b>106</b>
--	------------	------------	------------	------------

\*- Үзүүлэлт тус бүрээр хийсэн дэлгэрэнгүй үнэлгээг хавсралт хүснэгтээр харуулав.

ОУ-ын байгууллагаас гаргасан тооцох аргачлал, арга зүй нь бэлэн байгаа 135 үзүүлэлтийн 58 нь Монгол улсын хувьд гарах боломжтой, 77 нь одоогоор гаргах боломжгүй, мэдээллийн эх үүсвэрийг бий болгох, тооллого, судалгаа, мэдээ, тайлангийн асуулгад нэмэлт асуулт тусгах, өрхөд суурилсан шинэ судалгаа явуулж тодорхойлох шаардлагатай үзүүлэлтүүд байна.

**3. Тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлтүүдэд хийсэн үнэлгээ.** ТХЗ-ын шалгуур 241 үзүүлэлтээс МУ-д хамааралгүй 13 үзүүлэлтийг хасч, үлдсэн 228 үзүүлэлтийн гаргах боломжид үнэлгээ хийхэд 71 үзүүлэлт нь гаргах боломжтой, (үүнээс 60 үзүүлэлт нь шууд гаргах, 11 үзүүлэлт нь дахин тооцоолол хийж, задаргаа тус бүрээр гаргах боломжтой), 157 үзүүлэлт нь мэдээллийн эх үүсвэр, тооцох аргачлал, арга зүйг бий болгох, тооллого, судалгаа, мэдээ, тайланд нэмэлт асуулт тусгах, тусгайлсан судалгаа явуулж гаргах шаардлагатай үзүүлэлтүүд байна.

Хүснэгт 2

**Тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлтүүдэд хийсэн үнэлгээ**

		ТХЗ-ын үзүүлэлт, бүгд	Монгол улсад хамаарал-гүй	МУ-д хамааралтай ТХЗ-ын үзүүлэлт, бүгд	Шууд гарах үзүүлэлт	Нэмэлт тооцоолол хийж, гаргах үзүүлэлт	Гарахгүй үзүүлэлт
1	Ядуурлыг устгах	12		12	2	3	7
2	Өлсгөлөнг зогсоох	14		14	4		10
3	Эрүүл мэндийг дэмжих	26	2	24	16	1	7
4	Чанартай боловсролыг дэмжих	11		11	3	0	8
5	Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах	14	1	13	0	2	11
6	Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	11		11	6	1	4
7	Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	6		6	3		3
8	Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох	17		17	10		7
9	Инноваци болон дэд бүтцийг нэмэгдүүлэх	12		12	3		9
10	Тэгш бус байдлыг бууруулах	11		11	1		10
11	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	15		15	1	1	13
12	Хариуцлагатай хэрэглээг дэмжих	13		13	1		12
13	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	7		7	2	1	4
14	Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах	10	10	0	0		0
15	Хуурай газрын эко системийг хамгаалах	14		14	4		10
16	Энх тайван, шударга ёсыг цогцлоох	23		23	2	2	19

17	Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	25		25	2		23
	<b>Дүн</b>	<b>241</b>	<b>13</b>	<b>228</b>	<b>60</b>	<b>11</b>	<b>157</b>

**4. Тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлтийг тооцох, гаргах чиглэлээр цаашид хийгдэх шаардлагатай ажлууд.** УБСЕГ-аас ТХЗ-ын Дэлхийн болон үндэсний түвшний үзүүлэлтүүдийг тооцох, гаргах чиглэлээр дараах ажлуудыг хийж, гүйцэтгэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Яамд, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ТХЗ-ын Дэлхийн болон үндэсний түвшний үзүүлэлтүүдийг тооцох олон улсын аргачлал, арга зүйг судлах, үндэсний онцлогт нийцүүлэн боловсруулах, мөрдүүлэх;
- Аргачлал, арга зүй нь бэлэн боловч гаргах боломжгүй үзүүлэлтүүдийг тодорхойлж, тусгайлсан судалгаа явуулах, одоо мөрдөгдөж байгаа зарим тооллого, судалгаа, мэдээ, тайлангийн маягтад шаардлагатай нэмэлт асуултыг тусгаж, мэдээллийн эх үүсвэрийг бий болгох;

Эцэст нь нэгдсэн Тогтвортой хөгжлийн Үндэсний хороо болон Сангийн яамны зүгээс дараах ажлуудыг зохион байгуулж, анхаарал тавин ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд Олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, шинжлэх ухаан, судалгаа шинжилгээний байгууллагуудыг татан оролцуулах, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх;
- ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн аргачлал, арга зүйг боловсруулах, үндэсний, орон нутгийн түвшний болон салбарын бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах, үнэлгээ хийх, албан ёсны монгол, англи орчуулгыг хийх, мэдээллийн эх үүсвэрийг бий болгох шаардлагатай судалгаа, шинжилгээний ажлыг хийхэд санхүүгийн тусламж авах зэрэгт холбогдох байгууллагууд, тухайлбал, олон улсын байгууллагын туслалцааг авах, хамтран ажиллах;
- ТХЗ-ыг гаргах мэдээллийн эх үүсвэрийг бий болгох, тусгайлсан судалгаа явуулахад шаардагдах санхүү, зардлын асуудлыг шийдвэрлэх;
- ТХЗ-ын дэлхийн болон үндэсний түвшний үзүүлэлтүүд батлагдсны дараа тодорхой сэдвүүдээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

**Ашигласан материал:**

1. ТХЗ-ын үзүүлэлтийн мета мэдээллийн сан:  
<http://unstats.un.org/sdgs/iaeg-sdgs/metadata-compilation/>
2. Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал:  
<http://web.nso.mn/AZMS/web/content/21>

3. Бусад холбогдох аргачлалууд

<http://web.nso.mn/aazms/>